



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 20 өдөр

Дугаар А/283

Улаанбаатар хот

Согтууруулах ундаа худалдах, түүгээр
үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох,
хүчингүй болгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 15.8, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.2, 18.1.5, 18.1.8, 18.1.12, 18.1.13, 20 дугаар зүйлийн 20.1.7, Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.6, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 30.1, 30.2 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/847, 2024 оны А/219 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн Засаг даргын 2024 оны А/244 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн 2025 оны 10 дугаар хурлын тэмдэглэлийг үндэслэн спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл шинээр олгох 2 хуулийн этгээдийн жагсаалтыг нэгдүгээр, спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох 2 хуулийн этгээдийн жагсаалтыг хоёрдугаар, спиртийн сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох 1 хуулийн этгээдийн жагсаалтыг гуравдугаар, согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох 3 хуулийн этгээдийн жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Согтууруулах ундааг худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгогдсон хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс (Б.Номин), Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газар (Ц.Амгалан-Энх), дүүргийн 1-24 дүгээр хорооны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Үнэт цаасны бичилт, олголт, хураамжид байнгын хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхбаяр), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д тус тус даалгасугай.

4. Улаанбаатарын хотын Ерөнхий менежерийн 2024 оны А/29 дүгээр тушаалын "Бренд Нью Баарс" ХХК, А/42 дугаар тушаалын "Зол Манлай" ХХК, дүүргийн Засаг даргын 2024 оны А/290 дүгээр захирамжийн хоёрдугаар хавсралтын "Баруун Монгол Засагт Хаан" ХХК-ийн холбогдох хэсгийг тус тус хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ



1525010822